



Шинжээчийн тайлан

(Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл)

Байгууллагын нэр: Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: Нийгмийн ажил

Индекс: D 092301

Шинжээчийн баг:

Ахлагч: Ч.Байгалмаа /МУБИС-ийн БоСС-ийн тусгай хэрэгцээт
боловсролын тэнхимийн ахлах багш/

Гишүүд: Л.Хандмаа /АШУҮИС-ийн НЭМС-ийн нийгмийн ажлын
ахлах багш/

Л.Алтангэрэл /Монголын Аутизмын холбоо ТББ-ын
гүйцэтгэх захирал/

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Олон Улсын Улаанбаатар Их Сургууль International University of Ulaanbaatar	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Нийгмийн ажил Social work	
Индекс	D 092301	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. Ч.Байгалмаа – МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн ахлах багш 2. С.Хандмаа – АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Нийгмийн ажлын ахлах багш 3. Л.Алтангэрэл – Монголын Аутизмын Холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал 	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	1. Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2020-05-25 Даваа гараг	Удирдлага болон өөрийн үнэлгээний багтай уулзах: Удирдлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойшх мэдээллийг оруулах/
	2020-05-25	Сургуулийн орчинтой танилцах
	2020-05-25	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана
	2020-05-25	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	2020-05-25	Шинжээчдийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	2020-05-26 Мягмар гараг	Багш нартай хийх уулзалт
	2020-05-26	Оюутнуудтай хийх уулзалт
	2020-05-26	Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах
	2020-05-26	Ажил олгогчдын төлөөлөлтэй уулзах
	2020-05-26	Шинжээчдийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	2020-05-26	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ
Шалгуур шаардлага /журам/	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ОУУБИС нь Нийгмийн ажлын хөтөлбөрийг 2013 оноос эхлэн хэрэгжүүлж, 2016 оноос нийгмийн ажилтнуудыг зах зээлд бэлтгэн гаргасан байна.

Хөтөлбөрийн зорилго:

Хувь хүн, гэр бүл, олон нийтэд нийгмийн суурь үйлчилгээг хүргэх мэдлэг, ур чадварт суралцсан, нийгмийн бодлого, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж ажиллах, үйлчлүүлэгчид тулгамдсан асуудлыг оновчтой тодорхойлох, төлөвлөх, үйлчилгээний үр дүнг үнэлэх чадвартай, мэргэжлийн өндөр ёс зүйд суурилсан харилцаа, хандлагатай, багаар ажиллах дадал эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэх

Хөтөлбөрийн хүрэх үр дүн

А. Хөтөлбөрийн ерөнхий суурь агуулгаар суралцагчид дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх

Б. Хөтөлбөрийн мэргэжлийн суурь хэсгийн агуулгаар суралцагчид нийгмийн ажил мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол-арга зүйн мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэх

- Мэргэжлийн удиртгал, Нийгмийн ажлын ёс зүй, түүх философи, нийгмийн ажлын онол, арга зүй, нийгмийн ажлын менежмент, нийгэм, эдийн засгийн хөгжил, хүүхэд хамгаалал, нийгмийн хамгааллын бодлого хичээлийн онолын мэдлэг эзэмших
- Гадаад хэл дээр мэргэжлийн мэдээлэл ашиглах, мэдээллийн хоёр дахь эх үүсвэрийг ашиглах, нийгмийн асуудал, үзэгдлийг судлах, шийдвэрлэх ур чадвар эзэмших
- Хувь хүний төлөвшил, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх, багаар ажиллах, цагийн менежмент, нийгмийн хариуцлагатай мэргэжилтэн байна.

В. Хөтөлбөрийн мэргэжлийн хэсгийн агуулгаар суралцагчид зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн ажил мэргэжлийн хичээлийн мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэх

- Нийгмийн халамж үйлчилгээний онол, арга зүй, Хүүхэд, гэр бүлтэй ажиллах арга зүй, нийгмийн хамгааллын бодлого, эрх зүйн орчин, хүн ам зүйн бодлого, эрх зүйн орчин, хүн ам зүйн бодлого, нийгмийн халамж үйлчилгээний төрөл, зөвлөн туслах үйлчилгээний талаарх мэдлэгийг эзэмшүүлэх
- Нийгмийн ажлын үйлчилгээг хувь хүн, гэр бүл, байгууллага, олон нийтэд хүргэх арга замыг оновчтой тодорхойлох, нийгмийн ажлын үнэт зүйлс, ёс зүйн зарчмуудыг ашиглах, оролцоог чухалчлах сэтгэлгээг хөгжүүлэх, олон нийтийг чадваржуулах, гэр бүл, хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд олон нийтийг татан оролцуулах
- Үзэл бодлоо зөв илэрхийлдэг, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй ханддаг, өөрийгөө хөгжүүлдэг, өөртөө итгэлтэй, зорилготой, ёс зүйтэй, цагийн менежменттэй ажиллах, үнэлэлт дүгнэлт хийж, шинийг эрэлхийлэгч байх

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

Хичээлийн төрөл	Заавал судлах хичээлийн	Сонгон судлах хичээлийн	Нийт судлах хичээлийн	
	кр	кр	кр	%
Ерөнхий суурь	36	-	36	29
Мэргэжлийн суурь хичээл	23	8	31	25
Мэргэжлийн хичээл	37	13	50	41
Дадлага			6	5
Нийт дүн	96 (78%)	21 (17%)	123	100.0

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ, хөтөлбөрийн зорилго, төлөвлөлтийн баримт бичгүүдэд хамаарах бүхий л нотлох баримтууд болох сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрүүд, хэрэгцээний судалгаа, хөтөлбөрийн хороо, дэд хорооны дүрэм, журам, протоколууд зэрэг шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөөг АНУ-ын Нью-Йоркийн их сургууль, Сөүлийн их сургууль болон дотоодын их сургуулиудын хөтөлбөртэй харьцуулж, ялгаатай болон ижил төстэй талаар дүгнэлт хийсэн байна.
- Хөтөлбөр нь гэр бүл, хүүхдийн чиглэлийн агуулга, сайн дурын ажлыг сургалтын хөтөлбөртэй уялдуулсан байна.

Анхаарах асуудал:

- Гадаад, дотоодын сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулахдаа дэлгэрэнгүй, тайлбар, дүгнэлт хийх хэрэгтэй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагын үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалах гэсэн шалгуурын хүрээнд олон улсын нийгмийн ажлын боловсролын холбоодоос зөвлөмжилсөн хичээлүүд, агуулгыг тусгахад анхаарах хэрэгтэй.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн зорилгыг байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн байдлыг илэрхийлэх нотолгоо баримтуудыг бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэжлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, оролцогч талуудын хэрэгцээнд нийцсэн байдлыг үндэслэлтэй тайлбарласан

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох өөрчлөлтийн талаар олон нийтэд сургуулийн цахим хуудсаар мэдээлсэн, шинэ элсэгчдэд зориулсан тараах материал боловсруулсан, сургалт сурталчилгааг эцэг эх, ажил олгогч, элсэгчиддээ мэдээлж ажиллажээ.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг төгсөгч ямар мэдлэг, чадвар, хандлагыг эзэмших талаар дэлгэрэнгүй тусгаагүй
- Оролцогч талуудын хэрэгцээг судлахдаа төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудыг өргөн хүрээнд хамруулах нь чухал.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн төгсөгчийн загвар буюу хөтөлбөрийн төгсөгч “хэн” байхыг тодорхойлсон төгсөгчдийн эзэмших цогц чадамжийг боловсруулах шаардлагатай /blueprint/.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдтэй холбоотой нотлох баримтуудыг бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулиас хөтөлбөр боловсруулах арга зүйн гарын авлага гаргаж, БСШУЯ-ны сайдын 174 тоот тушаалд нийцүүлэн нэгж хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулжээ.
- Сургалтын хөтөлбөрт оруулсан өөрчлөлтүүдийг цэгцтэй илэрхийлж, багц цагийн өөрчлөлт, сургалтын арга зүйн өөрчлөлт, залгамж холбоо, хөтөлбөрийн дотоод агуулгын өөрчлөлт, үнэлгээний олон талт аргуудын талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.

Анхаарах асуудал:

- Зарим хичээлийн хөтөлбөрийг баталсан гарын үсэггүй, тамгагүй байсан бөгөөд зарим хичээлийн файлын сан дутуу байв.
- Хөтөлбөрт лекцийн эзлэх хувь өндөр байна.

Зөвлөмж:

- Нэгж хичээлийн хөтөлбөрийг бүрэн бүрдүүлэх, хичээлүүдэд практик дадлагын эзлэх хувийг нэмэгдүүлэх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Хичээлийн удирдлага мэдээллийн систем дэх сонголтууд, сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ, дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа зэрэг шаардлагатай баримт нотолгоог бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Сургалтын хөтөлбөрийг давтамжтай өөрчилж, сайжруулсан байна.
- Дадлагын талаарх хамтарч ажилладаг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ хийж, оюутнуудаа тогтмол дадлага хийлгэж байна.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг шинжилгээг хийхдээ оновчтой аргыг ашигласан.
- Хичээл хоорондын залгамж холбоог оновчтой зураглалаар илэрхийлсэн.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн цагийн ачааллыг тооцсон боловч зохистой хэмжээ эсэх талаар дүгнэлт, тайлбар шаардлагатай.
- Хичээлийн агуулгын давхардал байгаа эсэх, ямар түвшинд байгаа талаар тайлбар дүгнэлт хийгдээгүй.

Зөвлөмж:

Хичээлийн агуулгын давхардал байгаа эсэхийг нэгж хичээлийн хөтөлбөр тус бүрийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцэх үедээ нарийвчлан авч үзэх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын арга зүйг тусгасан нэгж хичээлийн хөтөлбөрүүд, сургалтын арга зүйд хийсэн анализ зэрэг шаардлагатай бүх нотолгоог бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүйн хувьд семинарын хичээлд асуудал суурилсан, нөхцөлд суурилсан зэрэг олон талын аргыг ашиглаж байна.

- Суралцагч төвтэй сургалтын аргуудыг дийлэнх хичээлүүд семинар, дадлагын хичээлүүддээ тусгасан байна.

Анхаарах асуудал:

- Сургалтад сургалтын дэвшилтэт технологийг ашиглах

Зөвлөмж:

- Дадлага, семинарын хичээлд ашиглагддаг аргууд нь асуудалд суурилсан, нөхцөлд суурилсан сургалтын аргуудаар явагдаж байгаа нь оновчтой боловч лекцийн хичээлийн хувьд арга хэлбэр цөөн байгааг анхаарах
- Оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч байгаа боловч хөтөлбөр болон нэгж хичээлийн хөтөлбөрт хэрхэн тусгаж байгаа нь тодорхой бус байгааг анхаарч ажиллах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчийн үнэлгээний талаар харьцуулсан мэдээлэл, явцын болон төгсөлтийн шалгалтын журам, суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулал зэрэг нотолгоог бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргуудыг дэлгэрэнгүй тайлбарласан
- Хичээл нэг бүрт шалгалтын олон хэлбэрүүдийг ашигладаг байна.

Анхаарах асуудал:

- Сурлагын амжилт чанарыг 5 жилээр харьцуулан үзүүлжээ, F үнэлгээтэй оюутнууд нэмэгдэж буй талаар дурьдахдаа шалтгаан, дэмжлэгийн тогтолцоог хөгжүүлэх

Зөвлөмж:

- Сорилд үнэлгээг хэрхэн хийх аргаа сонгож, сайжруулалтыг тогтмол хийх
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд тогтмол дүн шилжилгээ хийх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Үндсэн их сургуулийн тухайд өргөн хүрээний газар нутагт хичээлийн анги танхимын бааз суурь, багшийн ажиллах орчин, оюутнууд жижиг бүлгээр ажиллах зэрэг орчин нөхцөл хангалттай бүрдсэн байна. Мэдээллийн технологийн хэрэгсэл ба цахим орчны ашиглалт, цахим орчны ашиглалтын аюулгүй байдлыг хангах хамгаалалтын программ хангамж хэрэглэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн шинэ байр баригдсантай холбогдуулан сургуулийн орчин болон дотоод, гадаад тохижилт хангалттай сайн хийгджээ.
- “Дотоод орчин сайтай шилдэг сургууль”-аар шалгарч байсан зэрэг нь үүний илрэл болох буйзаа.
- Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг ОУ-ын жишигт нийцэхээр байгуулсан байна.
- Багш мэргэжилтний ажиллах орчин, оюутны бие даан ажиллах, Сайн дурын үйлчилгээний төв зэргийг онцолж болох юм.

Анхаарах асуудал:

- Сургалтын орчин үзүүлэлтэд Шууд хамааралтай бус ч сургуулийн 1-р байрны орчны автомашины зогсоол, Эко худалдааны төв, мөн 2-р байрнаас зам хөндлөн гарч 1-р байр руу шилжих үеийн осол аюулгүй байдал, эрсдэлтэй нөхцөл байдлыг тооцсон зөвлөмж, авах арга хэмжээний талаар авч үзэх нь зохистой.

Зөвлөмж:

- Орчин нөхцөлийн хувьд МУ-ын хэмжээнд хангалттай хэдий ч ОУ-ын жишгээр багш бүр өрөөтэй байх нь оюутан багштай зөвлөлдөх, ганцаарчилсан уулзалт хийх боломжтой болж энэ нь бусад багшдаа ч саад болохгүй, мөн ганцаарчилсан зөвлөгөө авах зэрэгт илүү үр өгөөжтэй байх боломжтой.
- Шинээр нээгдэж буй танхимын ашиглалт, зохион байгуулалтыг сайжруулж чадвал бүрэн дүүрэн ажиллахад дөхөмтэй болно.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дотоод сүлжээ, цахим ном, гадаад эх сурвалж зэрэг нэмэлт хэрэглэгдэхүүн, бусад мэдээлэл эх сурвалж ашиглах тал дээр боломжийн бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Монгол хэл дээр эх сурвалж, ном сурах бичгийн хүрээнд дүгнэвэл гэр бүл, хүүхэд хамгаалал гэсэн чиглэлийн ном сурах бичиг харьцангуй хангалттай байгаа хэдий ч нийгмийн ажлын чиглэлээр хэрэгцээтэй үндсэн сурах бичиг болон нэмэлт сурах бичгийн нэр төрөл, хүрэлцээ хангалтгүй байна.
- Нийт сурах бичгийн агуулгаас авч үзэхэд үндсэн сурах бичгийн хэрэгцээ

Зөвлөмж:

- Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр ялангуяа ОБ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ТББ-тай хамтран ажиллах зэргээр холбогдох мэргэжлийн гарын авлага, материалыг сургалтандаа оруулж ашиглах нь зохистой болов уу. Жишээ нь: Монголын Дауны Холбоо, Монголын Аутизмын Холбоо зэрэг энэ чиглэлээр тодорхой хэмжээнд үйл ажиллагаа явуулж, харьцангуй мэргэшсэн байгууллага цөөнгүй байдаг.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС нь өөрийн гэсэн том номын сантай ба цэвэрхэн тохилог орчинд бие даан ажиллах, суралцах орчин нөхцөл хангагдсан байв.
- Мөн англи болон солонгос хэлээр сүүлийн үеийн мэдээлэл, шинэ ном товхимолыг шуурхай авах бүрэн боломжтой байна.
- Номын сангийн хэсэгт Тусгай хэрэгцээ шаардлагатай оюутан болон хэрэгцээтэй бүлэгт зориулагдсан бичиг, үсэг томруулж харах боломжтой компьютер нэвтрүүлжээ.

Анхаарах асуудал:

- Үндсэн сурах бичиг, нэмэлт сурах бичгийн төрөл цөөн байв. Тус салбар нь өөрөө шинэ, нийгэм цаг үеэ дагаж урсгал, чиг хандлага өөрчлөгддөг хэдий ч тухайн цаг үе, нөхцөл байдлаа мэдэрсэн өөрийн гэсэн сурах бичиг байх хэрэгцээ шаардлага өндөр гэж харж байна.

- Гадаад хэлээр эх сурвалж байгаа хэдий ч мэргэжлийн нэр томъёоны асуудал, цаашлаад оюутнуурын хэлний тодорхой хэмжээний бэрхшээлээс үүдэн бүрэн дүүрэн мэдээлэл авах нь хүндрэлтэй байж болзошгүй.

Зөвлөмж:

- Үндсэн сурах бичгийн төрөл цөөн санагдав. Тус салбар нь өөрөө шинэ, нийгэм цаг үеэ дагаж урсгал, чиг хандлага өөрчлөгддөг хэдий ч тухайн цаг үе, нөхцөл байдлаа мэдэрсэн өөрийн гэсэн сурах бичиг байх хэрэгцээ шаардлага өндөр гэж харж байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, салбар, дэд хороо байгуулан, нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах чиглэлээр ихээхэн анхаарч ажиллан, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмуудыг цэгцэлж хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч, ажил олгогч зэргээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг хөтөлбөрийг сайжруулахад ашиглаж байна.
- Стратеги төлөвлөгөөгөө 10 жилээр, 3 үе шаттайгаар боловсруулан түүний хүрээнд жил жилээр богино хугацааны төлөвлөлтөө хийж, хэрэгжүүлж байна.
- Багш нарын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны биелэлтийг хариуцсан алба нэгжээр үнэлүүлэн ажиллахын зэрэгцээ санал гомдол, түүнийг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж чадсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн удирдлага мэдээллийн системийн ашиглалтын судалгаа хийж, үр дүнг эргэх холбоогоор ашиглахад анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн удирдлага мэдээллийн системийн ашиглалтын судалгааг багш, суралцагч, бусад холбогдох мэргэжилтнүүдээс авч, түүний үр дүнд тулгуурлан хэрхэн сайжруулах талаар дүн шинжилгээ хийх

- Удирдлага мэдээллийн системийг ашигласнаар хөтөлбөрийн хэрэгжилтэд гарсан ахиц өөрчлөлтийн талаар судлан, дүн шинжилгээ хийх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Тус сургууль нь БНСУ, ОХУ, АНУ, БНХАУ зэрэг улс орнуудын 95 их дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллахын зэрэгцээ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь эдгээр сургууль болон дотоодын олон байгууллагатай хэд хэдэн чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, НХХЯ, ХХҮЕГ, НХХҮГ, Нийгмийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай оюутны дадлага, сайн дурын үйл ажиллагаа, мэргэжлийн сургалт семинар, эрдэм шинжилгээ хурал, уулзалт зөвлөгөөн, олимпиад зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байгаа нь багш суралцагчдын мэргэжлийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь гадаад, дотоодын их дээд сургууль, нийгэмлэг, төвүүдтэй хамтран ажиллаж, багш болон оюутан суралцагчдыг хөгжүүлэхэд нэлээд анхаарч ажиллаж байгаа нь сайшаалтай байна. Багш, оюутан солилцоог хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна. Гадаадын их сургуулийн зочин багш авчирч ажиллуулахын зэрэгцээ жил бүр багш нараа туршлага судлуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамруулж байна.
- Нэлээд онцлог зүйл бол оюутны сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр хамтын ажиллагааг тогтвортой бүрдүүлж, амжилттай ажиллаж байна. Мөн хувь хүний хөгжлийн сургалтуудыг ЕБС-ийн хүүхдүүд, сурагчдын эцэг эхэд зориулан амжилттай зохион байгуулсан байна.
- Нийгэмд чиглэсэн үйлчилгээг багш суралцагчдын оролцоотойгоор зохион байгуулж хэвшсэн давуу тал ажиглагдаж байна. Мэргэжлийн сургалт семинарыг нийгмийн ажилтнуудад төдийгүй бусад холбогдох мэргэжилтнүүдэд үнэ төлбөргүй сургалтуудыг зохион байгуулсан байна.
- ХХҮЕГ, НХХҮГ болон БНСУ-ын Сайн дурын үндэсний нийгэмлэгт, Сөүл хотын сайн дурын төвтэй хамтран Монголд сайн дурын нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Сургуулийн нэгдсэн орлого, зарлага, үүнээс хэд нь нийгмийн ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжид зарцуулагддаг хувь хэмжээг тодорхой тусгасан байна. Нэг суралцагчид ноогдох зардлын тооцоо, хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэл, өөрчлөлтөд зориулсан зарцуулалтыг хичээлийн жил тус бүрээр гаргаж, дүн шинжилгээ хийжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн зүгээс оюутан, багш нарт зориулан олон төрлийн тэтгэлэг олгодог бөгөөд энэ нь тэдний хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг байна.
- Сургалтын төлбөрөөс гадна амжилттай ажиллаж буй төгсөгчдийн зүгээс суралцагчдад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх байдал бүрэлдэж бий болсон давуу тал ажиглагдсан.
- Оюутны практик үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээний ажилд зориулсан санхүүжилт сүүлийн жилүүдэд тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалттай холбоотой зардал мөн адил өссөн үзүүлэлттэй байгаа нь хөтөлбөрийн тогтвортой байдлыг илэрхийлж байна.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжил, сургалт семинар, мэргэжил дээшлүүлэх, багш нарын эрдэмжилт зэрэгт зарцуулсан зардлын тухай мэдээллийг бусад үзүүлэлтийн адил тодорхой гаргаж, дүн шинжилгээ хийх

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш оюутны хөгжилд үзүүлж буй олон талын эх үүсвэрийн мөнгөн бус дэмжлэгийг тооцож, дүн шинжилгээ хийх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгаа, дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ, хөтөлбөрийг сурталчлах, олон нийтэд таниулах арга хэмжээг хангалтай хийж байна. Тухайлбал, жил бүр 4-6 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийгмийн ажилтны ажлын байранд тавигдах шаардлагыг төгсөгчдийнхөө ажилладаг салбар болон байгууллагыг хамруулан судалж, дүн шинжилгээ хийсэн байна.
- Мэргэжил сурталчлах өдөрлөгийг жил бүр тогтмол хийж хэвшсэн бөгөөд ЕБС-ийг төгсөгчдөд чиглэсэн мэргэжил сонголт, хувь хүний хөгжлийн болон бусад чиглэлийн

сургалтаар дамжуулан тэдэнд нийгмийн ажил хөтөлбөрийн онцлог, давуу тал зэргийг таниулах ажлыг зохион байгуулсаар иржээ.

- Мөн мэргэжилтнүүдийн дунд уулзалт хэлэлцүүлэг, сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах нь хөтөлбөрийг хэрэгжүүлж буй нэгж, түүний үйл ажиллагаа, суралцагч оюутнууд, төгсөгчдийн талаар олон нийтийн дунд ойлголт мэдээллийг түгээн дэлгэрүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна.
- Сургуулийн зүгээс олон талын идэвхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Тухайлбал, сургуулиа сурталчлах телевизийн зар сурталчилгаа, үйл ажиллагааны хөтөлбөр бүхий хуудас, танилцуулгыг тараах, ЕЭШ-д бэлтгэх сургалтууд, Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Анхаарах асуудал:

•

Зөвлөмж:

- Хөтөлбөр сурталчлах үйл ажиллагаа тус бүрийн үр дүн буюу үр ашгийг тандан судалж, дүн шинжилгээ хийх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Удирдлага, мэдээллийн системийг ашиглаж хэвшсэн байдал ажиглагдаж байна. Хөтөлбөрийн ил тод байдлыг хангах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байна. Сургуулийн вэбсайт, түүний контент жил бүр сайжирч, холбогдох дүрэм журмыг байршуулж, мэдээлэл нэмэгдэж байгаа нь боломжийн түвшинд байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагаанд “Оюутан, багш, ажилчдын нэгдсэн мэдээллийн систем” (Edmodo)–ийг ашиглаж байна.
- Олон нийтэд ил тод, үнэн зөв, бодит мэдээлэл хүргэхэд сургуулийн вэбсайт, оюутны гарын авлага, facebook, оюутнууд болон төгсөгчдийн facebook, сонин, сэтгүүл, радио, телевик, элсэгчдэд зориулсан сэтгүүл, тараах материал зэргийг ашигладаг байна.
- Сургууль нь өөрийн гэсэн вэбсайтаар бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж тэнхимүүд өөрсдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухай бүрт нь тус вэбсайтаар дамжуулан мэдээлдэг байна. Тус сайтаар дамжуулан холбогдох дүрэм журам бодлого, элсэлт, сургалтын хэлбэр, төлбөр, тэтгэлэг, хамтын ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц бүрэлдэхүүн, хөтөлбөрийн талаарх ерөнхий мэдээлэл, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа зэргийн талаар нээлттэй ил тод мэдээлж байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжил танилцуулах өдөрлөг нь шинэ элсэгчдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, элсэн орсон хөтөлбөрийн агуулга, зорилгыг ойлгомжтой болгоход үр өгөөжтэй байна.
- Оюутны гарын авлага гаргаж тараадаг нь нэгдсэн мэдээлэл авах хангалттай эх сурвалж болж байна.

Анхаарах асуудал:

- ЕБС төгсөгчдийн тоо буурч байгаатай холбоотой хэдий ч сургуулиа, салбараа танилцуулах мэдээллийг тогтмол УБ хот болон орон нутагт сурталчлах үйл ажиллагаа явуулах нь үр дүнтэй болов уу.

Зөвлөмж:

- Сургуулийн хүчин чадлаа бүрэн ашигласан суралцагч элсүүлэх нь МУ-ын нөхцөлд бэрхшээлтэй хэдий ч чанартай элсэгч, мөн төгсөгч бэлтгэн гаргах тал дээр үндэсний төлөвлөгөө гаргавал зохистой болов уу.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн нь нөхцөл байдлыг тодорхой болгох, хөтөлбөрийг сайжруулахад тодорхой хэмжээнд үнэлэлт дүгнэлт хийхэд онцлог болсон болов уу.
- Суралцагчдад оюутны амьдралд дасах, хөлөө олоход нь туслах зорилгоор дээд ангийн суралцагчдын “tutor” тогтолцоог нэвтрүүлсэн байгаа нь сайшаалтай байна.

Анхаарах асуудал:

- Зөвлөн туслах үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг баяжуулах, тогтмолжуулах тал дээр илүү анхаарах.
- Бусад салбар чиглэлийн байгууллагатай Хамтран ажиллах тал дээр илүү анхаарах

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс санал асуулга авч, суралцагчдын эзэмших ёстой практикт түгээмэл ур чадварын талаар сургалтын болон бусад үйл ажиллагаанд оруулж өгвөл үр дүнтэй санагдана. Жиш: Зөв зохистой харилцаа, ярианы зөв дадал гэх мэт.
- Хөдөлмөр эрхлэлт, хууль эрх зүй, хөгжлийн бэрхшээлийн талаарх бусад байгууллага, иргэний нийгэм зэрэг газруудтай илүү хамтран ажиллах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутанд чиглэсэн олон төрлийн тэтгэлэг, хөтөлбөр их байгаа нь суралцагчийг идэвхжүүлэх, хичээлдээ анхаарлаа төвлөрүүлэх, цаашлаад бүтээлч байх, сайн дурын үйл ажиллагаа хийх урам зориг, идэвхийг өгөхөд ихээхэн үр өгөөжтэй байна.

Анхаарах асуудал:

- Дадлагын цагийг илүү нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн дадлагын хугацааг аль болох дадлага хийх газрын улирлын амралт зэрэг таараагүй үед хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна.
- Сайн дурын үйл ажиллагааг үнэлэх, нэмэгдүүлэх ажлыг хийж байгаа ч илүү өргөн хүрээг хамрах, сургуулиас гадуурх үйл ажиллагаанд энэхүү үнэлгээ нэвтэрдэг болох тал дээр илүү анхаарч ажиллах шаардлагатай санагдлаа.

Зөвлөмж:

- Суралцагч нь хөтөлбөрийн мөн чанар, цаашлаад энэ чиглэлийн чадварлаг хүний нөөц болох үүднээс Сайн дурын үйл ажиллагааг дэмжих, нэмэгдүүлэх, баяжуулах хэрэгцээ шаардлага өндөр гэж үзэж байна. Сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулж олон зүйлийг сурч мэддэг гэсэн ОУ-ын жишиг, шалгуурыг тооцон үзэж, энэ чиглэл рүү хүчтэй орох нь зохистой. Сургалтын агуулгад эмзэг бүлгийн болон нийгмийн дэмжлэг шаардлагатай ахмад настан, ХБИ, хүүхэд хамгааллын хичээл орж байгаа нь сайшаалтай ч хөгжлийн сүүдэрт үлддэг оюуны бэрхшээлтэй зэрэг нийгмээс ялгаварлан гадуурхалтанд өртөх магадлалтай бүлгийн талаар ойлголт мэдээлэлтэй байх, тэдгээр хүмүүстэй харилцаж чаддаг болох, нийгмийн стресс зэрэг НЭМ, бусад түгээмэл хөндөгддөг асуудалтай холбоотой үйл ажиллагаанд сайн дураар оролцох идэвхийг нэмэгдүүлэх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжил сурталчлах үйл ажиллагааны хүрээнд шилжиж ирэх тохиолдол цөөнгүй байна.
- Мөн олон чиглэлээр тэтгэлэг, хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авдаг нь сайшаалтай байна.

Анхаарах асуудал:

- Элсэн орсон суралцагчийг завсардуулахгүй байх талын арга хэмжээг боломжит хэмжээнд авах

Зөвлөмж:

- Суралцагчдад энэ салбарын эрэлт хэрэгцээ, үнэ цэнийг ойлгуулахын зэрэгцээ гэр бүл төлөвлөлт, ирээдүйн зорилгоо тодорхойлоход дэмжлэг үзүүлэхүйц уулзалт, сургалт, яриа хэлэлцүүлгийг тогтмол хийж байх.
- Хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлж, суралцагчийг идэвхжүүлэх тал дээр төсөл, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУ-д мөрддөг хууль журмын дагуу төгсөлтийн баримт бичгийг гаргаж байна.
- Мөн 2+2 хөтөлбөр хэрэгжиж эхэлвэл хос дипломтой төгсөж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрвөх чадвартай хүний нөөцийг хөгжүүлэх чухал алхам хэмээн харж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авч болох лавлагааны хэсэг байвал Ажил олгогч мэдээлэл авах тохиолдолд үнэн зөв, шуурхай мэдээллээр хангагдах боломжтой байх болов уу.

Зөвлөмж:

- Одоо суралцаж буй суралцагчдад ахисан түвшинд суралцах, цаашлаад хэрэгжиж эхлэх 2+2 хөтөлбөрийн уялдаа, боломж байгаа талаар судалж үзэх, нааштайгаар шийдвэрлэх.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын талаарх дүрэм журмууд, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хүний нөөц, багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа, багш нарт олгосон урамшуулал зэрэг шаардлагатай баримтуудыг бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн гүйцэтгэх ажлын хэмжээг албан тушаалын зэрэглэлийн дагуу ялгаатай тогтоож журамласан байна.
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааг чухалчилдаг байна.

Анхаарах асуудал:

- Багшийн аттестатчилалыг хэрхэн явуулж буй талаар тодорхой, үр нөлөөтэй мэдээлэл шаардлагатай

Зөвлөмж:

- Багш нарт гүйцэтгэлд суурилсан урамшууллын механизмыг хэрэгжүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

Багш нар мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хэрхэн гүйцэтгэж буй талаар болон багш нарын сургалтанд хамрагдсан гэрчилгээ, багш нарын төлөвлөгөө, тайлан, багшийн чадавхижуулалтын талаар баримт нотолгоог бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар хамтын ажиллагаатай Солонгос улсын их дээд сургуулиудад богино болон урт хугацааны сургалтуудад хамрагддаг.
- Багш нар ажлын төлөвлөгөө, тайланг тогтмол гаргадаг.

Анхаарах асуудал:

- Багш нарын суралцах хэрэгцээний талаар судалгааны мэдээлэл байхгүй

Зөвлөмж:

- Багш нарын суралцах хэрэгцээг нарийвчлан судалсны үндсэн дээр холбогдох сургалтуудад системтэй хамруулах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо: Багш нарын туурвисан ном, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл, хурлын илтгэлүүд зэрэг холбогдох баримт нотолгоог бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нэг багшид ноогдох эрдэм шинжилгээний бүтээлийн тоо харьцангуй өндөр байгаа бөгөөд сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлд ихэвчлэн хэвлүүлжээ.

Анхаарах асуудал:

- Боловсролын болон шинжлэх ухааны инноваци, ашигтай загвар, патентуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байв.
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээлэл тусгагдаагүй байв.
- Багш нары эрдэм шинжилгээний ажлыг олон улсын түвшинд хэвлэн нийтлэх талаар дэмжлэг үзүүлдэг талаар баримт нотолгоог бүрдүүлэх

Зөвлөмж:

- Багш нарын эрдэм шинжилгээний үнэлгээ болон эрдэм шинжилгээний ажилд зарцуулах зардлыг нэмэгдүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Багшийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээний чиглэлээр тайлан, төлөвлөгөө, түүнд хийсэн өөрийн үнэлгээний талаар баримтуудыг бүрдүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн төлөвлөгөө, тайлан түүний үнэлгээг тогтмол сайжруулж байгаа.
- Багшийн өөрийн үнэлгээний тайланд үндэслэдэг.
- Багшийн ачааллыг жил бүр бууруулах чиглэлээр анхаарч ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Багшийн тайланд хөндлөнгийн үнэлгээг хийх

Зөвлөмж:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланд хөндлөнгийн үнэлгээ хяналтыг сайжруулах, багшийн ажлын үнэлгээнд эрдэм шинжилгээний ажлын үнэлгээг нэмэгдүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц загварыг боловсруулан хэрэгжүүлсэн байна. 2019-2020 оноос эхлэн Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хариуцсан төвийг Сургалтын албаны доор шинээр байгуулан ажиллаж эхэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа нь хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хороогоор дамжин хэрэгжихээр хөтөлбөрийн хорооны журамд заасан бөгөөд хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд удирдлагаас гадна багш, ажил олгогч, төгсөгчдийн төлөөллийг оролцуулахаар журамласан байна.
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон төлөвлөлтийн дагуу хариуцсан нэгжүүд хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээ гэсэн үндсэн 3 бүлгийн хүрээнд нийт 15 төрлийн үнэлгээ судалгаа авч, Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хариуцсан төв тэдгээрийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тогтсон хугацаанд хөтөлбөрийн ерөнхий хороонд хүргүүлж хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Дээрх олон талын судалгаа, үнэлгээний үр дүнг ашиглан хөтөлбөр төлөвлөсөн үр дүнд хэр зэрэг хүрч чадаж байгаатай уялдуулан дүн шинжилгээ хийхэд анхаарах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, тухайн мэргэжлийн нийгэмд эзлэх байр суурь зэргийг судлан дүн шинжилгээ хийж, ажил олгогч, эцэг эхийн төлөөлөл, төгсөгчдөөс судалгаа авч дүн шинжилгээ хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн үр дүнг төгсөгч, ажил олгогч, эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаанд тулгуурлан шинжилсэн байна.
- Ажил олгогчдын зүгээс тус сургуулийн төгсөгчдийг бусад сургуулийн төгсөгчидтэй харьцуулахад төлөвшил сайтай, тогтвор суурьшилтай ажилладаг болохыг илэрхийлж байсан нь тус хөтөлбөр тодорхой хэмжээгээр сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцэж байгааг илтгэж байна.
- Мөн суралцагчдын сурлагын амжилтаар үнэлж, дүн шинжилгээ хийсэн бөгөөд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар судлах шаардлага байгааг тодруулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт элссэн суралцагчийн суралцах дундаж хугацааг судалж, дүн шинжилгээ хийхэд анхаарах

Зөвлөмж:

- Төгсөгчдийн хувьд карьерын өсөлтийн судалгааг хийхэд хангалттай хугацаа бүрдээгүй байгаа ч цаашид тус судалгааг хийх талаар төлөвлөх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчдынхаа цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дотоодын болон олон улсын тэмцээн уралдаан, олимпиадад оролцуулах, хөтөлбөртөө мэргэжлийн холбоодуудаар үнэлгээ хийлгэх, хэлэлцүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монголд нийгмийн ажилтан бэлтгэх чиглэлээр анхдагч болох МУБИС, ШУТИС зэрэг олон жилийн туршлагатай их сургуулийн мэргэжлийн тэнхим болон мэргэжлийн нийгмийн ажлын нийгэмлэг, холбоодод хөтөлбөрөө танилцуулж, хэлэлцүүлэн, дотоодын магадлан итгэмжлэл хийлгэх бэлтгэл ажлыг хангалттай сайн хийжээ.

- Мөн цаашид олон улсын магадлан итгэмжлэл хийлгэх, суралцагчдаа олон улсын түвшинд суралцах боломжийг бүрдүүлэхэд анхаарч, тодорхой төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөгчид нь мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөнийг нотлох баримт материалыг бүрдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс салбартаа манлайлж, амжилт гаргасан баримт мэдээллийг бүрдүүлэх

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **БҮРЭН ХАНГАСАН**

ДҮГНЭЛТ

Тус нийгмийн ажил хөтөлбөр нь нийгмийн эрэлт хэрэгцээ, улс орны бодлого, чиг хандлагатай нийцсэн хөтөлбөр бөгөөд тус хөтөлбөрөөр суралцагчид нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжтой нь тодорхой харагдаж байна

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2	1.2		
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	3.2		
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2	6.3		
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн “Нийгмийн ажил” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч Ч.Байгалмаа

Шинжээчийн багийн гишүүн Л.Алтангэрэл

Шинжээчийн багийн гишүүн С.Хандмаа

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Олон Улсын Улаанбаатар Их Сургууль
Хөтөлбөрийн нэр	Нийгмийн ажил
Хөтөлбөрийн индекс	092301
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагын үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалах гэсэн шалгуурын хүрээнд олон улсын нийгмийн ажлын боловсролын холбоодоос зөвлөмжилсөн хичээлүүд, агуулгыг тусгахад анхаарах хэрэгтэй. • Хөтөлбөрийн төгсөгчийн загвар буюу хөтөлбөрийн төгсөгч “хэн” байхыг тодорхойлсон төгсөгчдийн эзэмших цогц чадамжийг боловсруулах шаардлагатай /blueprint/
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн агуулгын давхардал байгаа эсэхийг нэгж хичээлийн хөтөлбөр тус бүрийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцэх үедээ нарийвчлан авч үзэх. • Оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч байгаа боловч хөтөлбөр болон нэгж хичээлийн хөтөлбөрт хэрхэн тусгаж байгаа нь тодорхой бус байгааг анхаарч ажиллах.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> • Үндсэн сурах бичгийн төрөл цөөн санагдав. Тус салбар нь өөрөө шинэ, нийгэм цаг үеэ дагаж урсгал, чиг хандлага өөрчлөгддөг хэдий ч тухайн цаг үе, нөхцөл байдлаа мэдэрсэн өөрийн гэсэн сурах бичиг байх хэрэгцээ шаардлага өндөр гэж харж байна.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Удирдлага мэдээллийн системийг ашигласнаар хөтөлбөрийн хэрэгжилтэд гарсан ахиц өөрчлөлтийн талаар судлан, дүн шинжилгээ хийх.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн хүчин чадлаа бүрэн ашигласан суралцагч элсүүлэх нь МУ-ын нөхцөлд бэрхшээлтэй хэдий ч чанартай элсэгч, мөн төгсөгч бэлтгэн гаргах тал дээр үндэсний төлөвлөгөө гаргавал зохистой мэт. • Төгсөгчдөөс санал асуулга авч, суралцагчдын эзэмших ёстой практикт түгээмэл ур чадварын талаар сургалтын болон бусад үйл ажиллагаанд оруулж өгвөл үр дүнтэй санагдана. • Хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлж, суралцагчийг идэвхжүүлэх тал дээр төсөл, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Багш нарын суралцах хэрэгцээг нарийвчлан судалсны үндсэн дээр холбогдох сургалтуудад системтэй хамруулах. • Багш нарын эрдэм шинжилгээний үнэлгээ болон эрдэм шинжилгээний ажилд зарцуулах зардлыг нэмэгдүүлэх.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Төгсөгчдийн хувьд карьерын өсөлтийн судалгааг хийхэд хангалттай хугацаа бүрдээгүй байгаа ч цаашид тус судалгааг хийх талаар төлөвлөх. • Төгсөгчдөөс салбартаа манлайлж, амжилт гаргасан баримт мэдээллийг бүрдүүлэх.
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
	➤

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас
1.	Т.Намжил	Багш	-Нийгмийн ажлын судалгааны арга зүй -Төрийн үйлчилгээ -Гэр бүлийн сурган хүмүүжүүлэх зүй	9928-0007
2.	Б.Сүх-Очир	Тэнхмийн эрхлэгч	-Нийгмийн ажлын удиртгал -Нийгмийн ажлын менежмент -Хүн амзүйн бодлого -Нийгмийн ажлын арга зүй-2 -Нийгмийн ажлын нөлөөлөл -Хүүхэдтэй ажиллах нийгмийн ажил	8906-7133
3.	Д.Мягмарсүрэн	Ахлах багш	-Нийгмийн ажлын онол -Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил -Нийгмийн ажлын арга зүй-1 -Нийгэм эдийн засгийн хөгжил -Хүний эрх шударга ёс -Хүүхэд хамгаалал -Хүүхэд судлал	9928-6888
4.	Ц.Энхтүвшин	Багш	-Нийгмийн ажлын түүх, философи -Сайн дурын нийгмийн үйлчилгээ -Нийгмийн халамжин үйлчилгээний арга зүй -Халамж үйлчилгээний үнэлгээ шинжилгээ -Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй	9181-2108

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	М.Мөнхбаяр	1-р курс	Орон нутаг	957490-33
2	Б.Янжинлхам	1-р курс	Орон нутаг	9915-2108
3	Ж.Гоомарал	2-р курс	УБ	9116-8599
4	Ж.Энхнаран	2-р курс	УБ	8939-7447
5	Е.Энхбадрал	2-р курс	УБ	8084-4377
6	Э.Саранцацрал	2-курс	Сайн дурын клуб	8894-2560
7	Э.Анужин	2-курс	УБ	8057-0858
8	Б.Төгөлдбаяр	3-р курс	УБ	8613-4977
9	Г.Нандин-Эрдэнэ	3-курс	УБ	88373885
10	Б.Шинэбаяр	4-р курс	Оюутны зөвлөл	99783064

11	Г.Дэлгэрсайхан	4-р курс	Орон нутаг	8056-0920
12	Ц.Батцэцэг	4-р курс	Сайн дурын клуб	8894-0113
13	Г.Саран-Эрдэнэ	4-р курс	УБ	8994-5262
14	О.Золбоо	4-р курс	Сайн дурын клуб	9120-2010

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	Ц.Туяасайхан	Захирал “Нарс” зуслан	9909-6109
2	Д.Тунгалаг	Найрамдал зуслан Ахлах арга зүйч	9610-9191
3	Н.Мөнхжаргал	Хөтөлбөрийн зохицуулагч Түгээмэл төв ТББ	8895-3883
4	С.Ундармаа	Сургалтын менежер	8030-1535
5	Х.Баавгай	Ерөнхий менежер “Сайн хөрш” ОУБ	9919-6592 l.baavgai@iuu.edu.mn
6	Б.Отгон	Ахлах нийгмийн ажилтан ХБХүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	Otgonbanzragch2@gmail.com
7.	Батчимэг	Хөдөлмөрийг дэмжих эмэгтэйчүүдийн холбоо	9908-5084
8.	Наранзаяа	“Холт Монгол”	8011-2400
9.	Түвшинжаргал	Чингэлтэй дүүргийн ХХҮ хэлтэс халамжийн албаны дарга	8911-0720
10.	Солонго	Дэлхийн зөн ОУБ	9900-7526
11.	Бямбабат	Сайн дурынханы хөгжлийн төв	9901-9645
12.	Цэндбаатар	Хүүхдийн асрамжийн газар	8890-7717

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас
1	Г.Даваажав	2016	Гүүд нейборс	89977024
2	Д.Сүх-Эрдэнэ	2016	Түгээмэл төв ТББ	89141713
3	О.Золжаргал	2017	Нарс зуслан	88637245
4	Ш.Мөнхзул	2017	“Хурд” асрамжийн газар	95735308
5	М.Роза	2017	Налайх дүүрэг ХХҮХ халамжийн нийгмийн ажилтан	89093125
6	Г.Бадамсүрэн	2018	Гүүд нейборс ОУ	95689828
7	Э.Сарангуа	2018	Хүүхдийн найрамдал зуслан	99799747
8	М.Жамьяанмядаг	2018	Нарс зуслан	88450840
9	Д.Нарантуяа	2019	Нийгмийн ажилтан Бадамлянхуа хүүхдийн төв Naагаа.naаgii0626@gmail	8550-8686
10	Б.Дуламжав	2019	Монгол Коосэн технологийн коллеж,	99567850
11	Д.Отгондаваа	2019	Нийгмийн ажилтан Бадамлянхуа хүүхдийн төв	88046605
12	Г.Долгормаа	2019	ТББ	88707872

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ

210644 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
Намянжүгийн гудамж, Утас: 462046 Факс: 976-11-462040
E-mail: info@iuu.edu.mn, iuu.edu.mn

2020. 06. 10 № 4/175

танай _____-ны № _____-т

Шинжээчийн тайлантай танилцсан тухай

Тус сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн “Нийгмийн ажил” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд өгсөн шинжээчийн багийн урьдчилсан тайлантай танилцлаа. Ямар нэг санал, хүсэлт, гомдол байхгүй болно.

Цаашид бидний зүгээс шинжээчийн багийн өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хөтөлбөрийг сайжруулах төлөвлөгөөг гарган ажиллах болно.

СУРГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА



Б.ОЮУН-ЭРДЭНЭ

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2020-06-15
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) 2020.6.16
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/